



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/230

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 134 дүгээр
цэцэрэлгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 250,500.0 /хоёр зуун тавин мянга таван зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 134 дүгээр цэцэрлэг /С.Гэрэлмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй нийт 250,500.0 /хоёр зуун тавин мянга таван зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн 134 дүгээр цэцэрлэг /С.Гэрэлмаа/-т үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 09...сарын
 09.. өдрийн А/230 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 134 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	8	ш	13		250,500.0	-	-	ашиглагдахгүй	устгах
Номын фондын дүн						250,500.0	-	-		
Нийт дүн						250,500.0	-	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө						250,500.0				
Татан төвлөрүүлэх хөрөнгө										
Худалдсанаас олох орлого										
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/										